

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/272/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ИРЭЭДҮЙ ЦОГЦОЛБОР
ЦЭЦЭРЛЭГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: auditulziit@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БҮТЭЗ	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол гэмтлээс шалтгаалах өвчин
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/123
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН
ИРЭЭДҮЙ ЦОГЦОЛБОР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ А.ОЮУНТУЛГА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 35,675.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул дараах асуудлуудыг хязгаарлалттай дүгнэлтийн үндэс гэж үзлээ. Үүнд:

- Тайлант хугацаанд 26,030.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн
- Цахим төлбөрийн и баримтын бүрдэл хангаагүй 8,411.7 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн
- Тайлант хугацааны тооллого хийхдээ 1,138.8 мянган төгрөгийн хөрөнгийг тоолж баталгаажуулаагүй
- Газрын бүртгэлд 3,623 м.кв газрыг зөрүүтэй бүртгэсэн.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 6 сарын 21-ны өдрийн 241 тоот тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох” албан хаагчдын цалингийн хэмжээнд өөрчлөлт орсон байна.

019020246

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээг дараах байдлаар тодорхойлж байна.

Тайлант 18,639,9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	115,086,891.27	236,379,318.65
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,760,130.67	122,455,817.05
312	Банканд байгаа бэлэн мөнгө	9,760,130.67	122,455,817.05
3121	Төгрөг	9,760,130.67	122,455,817.05
31	Төрийн сангийн харилцах	9,760,130.67	122,450,817.05
33	АВЛАГА	1,864.68	1,869.68
33100	Ажиллагсадтай холбоотой авлага	1,864.68	1,864.68
335	Бусад авлага		5.00
3351	Байгууллагаас авах авлага		5.00
35	БАРАА МАТЕРИАЛ	105,324,895.92	113,921,631.92
351	Түүхий эд материал	0.00	105,000.00
35130	Эм боох материал	0.00	105,000.00
354	Хангамжийн материал	105,324,895.92	113,816,631.92
35410	Бичиг хэргийн материал	146,249.00	81,200.00
35420	Аж ахуйн материал	7,300.00	
35450	Барилгын засварын материал	43,450.00	9,350.00
35460	Хүнсний материал	4,004,667.00	5,564,852.00
35470	Бусад хангамжийн материал	101,123,229.92	108,161,229.92
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	644,612,371.02	618,612,639.52
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	644,612,371.02	618,612,639.52
392	Биет хөрөнгө	576,922,037.22	551,024,217.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	655,330,937.47	655,330,937.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	(124,072,665.17)	(155,179,698.65)
39205	Машин тоног төхөөрөмж	61,167,405.27	73,168,405.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32,960,245.46)	(42,097,390.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,959,119.45	60,909,019.45
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,502,514.34)	(41,107,055.68)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,204,000.00	2,204,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,204,000.00)	(2,204,000.00)
393	Биет бус хөрөнгө	67,690,333.80	67,588,422.36
39301	Программ хангамж	521,334.10	521,334.10
39302	Хуримтлагдсан элэгдэл	(231,000.30)	(332,911.74)
39303	Бусад биет бус хөрөнгө	67,400,000.00	67,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	759,699,262.29	854,991,958.17
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	2,194,594.25	26,030,107.45
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	2,194,594.25	26,030,107.45
413	Өглөг	2,194,594.25	26,030,107.45
4132	Бараа үйлчилгээний бусад зардлын өглөг	2,194,594.25	24,473,515.45
4136	Бусад өглөг		556,592.00
41361+	Байгууллагад төлөх өглөг		556,592.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	757,504,668.04	828,961,850.72
51	Засгийн газрын хувь оролцоо	757,504,668.04	828,961,850.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	276,740,885.50	276,740,885.50

Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51101	Өмч:-төрийн	276,740,885.50	276,740,885.50
512	Хуримтлагдсан үр дүн	(200,815,785.10)	(129,358,602.42)
51210	Өмнөх үеийн үр дүн	(200,815,785.10)	(200,815,785.10)
51220	Тайлант үеийн үр дүн		71,457,182.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	681,579,567.64	681,579,567.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	759,699,262.29	854,991,958.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	988,354,334.10	1,170,774,419.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	673,732,734.10	970,423,319.86
120	Нийтлэг татварын бус орлого	2,913,734.10	19,635,219.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,913,734.10	19,635,219.86
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		995,319.86
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	2,913,734.10	18,639,900.00
122	Тусламжийн орлого	670,819,000.00	950,788,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	670,819,000.00	950,788,100.00
	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	314,621,600.00	200,351,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	98,175,600.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	98,175,600.00	0.00
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	216,446,000.00	200,351,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/ орон нутгийн төсөвт байгууллага/	216,446,000.00	200,351,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,022,988,416.33	1,099,317,237.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,022,988,416.33	1,099,317,237.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	924,683,406.58	1,096,599,759.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	533,781,299.00	630,918,895.98
210101	Үндсэн цалин	388,878,026.77	489,543,056.86
210102	Нэмэгдэл	121,934,647.77	126,760,119.91
210104	Урамшуулал	22,968,624.46	14,615,719.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,616,360.59	85,255,087.50
210201	Тэтгэврийн даатгал	45,645,347.75	60,084,331.06
210202	Тэтгэмжийн даатгал	5,370,041.11	6,433,209.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,269,152.72	5,128,967.74
210204	Ажилгүйдлийн даатгал	1,025,037.92	1,234,924.25
210205	Эрүүл мэндийн даатгал	10,306,781.09	12,373,654.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	172,297,794.25	221,960,021.20
210301	Гэрэл, цахилгааны зардал	9,427,635.00	14,254,009.90
210302	Түлш, халаалтын зардал	145,362,338.75	174,870,692.65
210303	Цэвэр, бохир усны зардал	17,507,820.50	32,835,318.65
2104	Хангамж, бараа материалын зардал	1,354,300.00	
210401	Бичиг хэрэг	930,800.00	
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	418,000.00	
210406	БҮТЭЗ	5,500.00	
2105	Норматив зардал	78,740,000.00	94,337,100.00
210502	Хоол, хүнс	78,378,300.00	94,337,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	361,700.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,241,800.00	2,038,800.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	1,241,800.00	2,038,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,651,852.74	62,089,854.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,631,040.00	16,139,223.00

Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	3,681,546.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,339,266.74	45,950,631.50
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,305,009.75	2,717,478.00
	Бусад урсгал шилжүүлэг	98,175,600.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,041,600.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	63,134,000.00	0.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт		2,717,478.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		2,717,478.00
	Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт	129,409.75	
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	129,409.75	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(34,634,082.23)	71,457,182.68
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (4)=(145-225)	5,885,720.00	
	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	5,885,720.00	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(28,748,362.23)	71,457,182.68

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,095,440,600.00	1,152,134,519.86
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,095,440,600.00	1,152,134,519.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	770,715,500.00	951,783,419.86
120	Нийтлэг татварын бус орлого		995,319.86
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		995,319.86
	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	770,715,500.00	950,788,100.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	770,715,500.00	950,788,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	324,725,100.00	200,351,100.00
	Улсын төвлөрсөн төсвөөс	10,000,000.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,000,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	98,279,100.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	98,279,100.00	0.00
1330	Орон нутгийн төсвөөс санхүүжих	216,446,000.00	200,351,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	216,446,000.00	200,351,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,020,870,308.33	1,036,721,355.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,020,870,308.33	1,036,721,355.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	922,565,298.58	1,036,721,355.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	541,933,135.79	636,367,773.88
210101	Үндсэн цалин	391,043,470.04	438,016,052.74
210102	Нэмэгдэл	126,352,398.94	178,985,526.53
210104	Үр дүнгийн урамшуулал	24,537,266.81	19,366,194.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,354,302.79	79,806,209.60
210201	Тэтгэврийн даатгал	49,427,725.51	54,436,306.81
210202	Тэтгэмжийн даатгал	5,768,998.35	6,417,049.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,611,778.63	5,109,164.40
210204	Ажилгүйдлийн даатгал	1,929,692.12	1,255,020.69
210205	Эрүүл мэндийн даатгал	10,616,108.18	12,588,668.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	192,774,300.00	198,601,100.00
210301	Гэрэл, цахилгааны зардал	11,107,910.00	12,404,800.00
210302	Түлш, халаалтын зардал	167,166,925.00	168,956,800.00
210303	Цэвэр, бохир усны зардал	14,499,465.00	17,239,500.00
2201	Хангамж, бараа материалын зардал	103,000.00	0.00
210401	Бичиг хэрэг	103,000.00	0.00
2105	Норматив зардал	88,046,445.00	95,897,290.00

Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	88,046,445.00	95,897,290.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,150,000.00	1,750,000.00
210604	Урсгал засвар	4,150,000.00	1,750,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,643,600.00	1,770,900.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	1,643,600.00	1,770,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,560,515.00	22,528,082.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,477,300.00	18,572,182.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,083,215.00	3,955,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,305,009.75	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	98,175,600.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	64,461,000.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	33,714,600.00	0.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	129,409.75	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	129,409.75	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	74,570,291.67	115,413,164.38
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	74,570,291.67	115,413,164.38
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	9,760,130.67
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	74,570,291.67	122,455,817.05

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	276,740,885.50	681,579,567.64	(142,665,200.63)	815,655,252.51
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	276,740,885.50	681,579,567.64	(142,665,200.63)	815,655,252.51
Тайлант үеийн үр дүн			6,044,895.98	6,044,895.98
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	276,740,885.50	681,579,567.64	(200,815,785.10)	757,504,668.04
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн	276,740,885.50	681,579,567.64	(200,815,785.10)	757,504,668.04
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал/			71,457,182.68	71,457,182.68
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	276,740,885.50	681,579,567.64	(129,358,602.42)	828,961,850.72

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		9,760,130.67	(9,760,130.67)	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,117,042,400.00	1,037,196,159.64	79,846,240.36	92.9%
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,117,042,400.00	1,037,196,159.64	79,846,240.36	92.9%
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,117,042,400.00	1,037,196,159.64	79,846,240.36	92.9%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	731,691,900.00	636,313,958.04	95,377,941.96	87.0%
Үндсэн цалин	461,781,000.00	437,962,236.90	23,818,763.10	94.8%
Нэмэгдэл	248,778,900.00	178,985,526.53	69,793,373.47	71.9%
Урамшуулал	21,132,000.00	19,366,194.61	1,765,805.39	91.6%
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	90,896,000.00	79,806,211.60	11,089,788.40	87.8%
Тэтгэврийн даатгал	62,063,800.00	54,436,306.81	7,627,493.19	87.7%
Тэтгэмжийн даатгал	7,301,400.00	6,417,049.13	884,350.87	87.9%
ҮОМШӨ-ний даатгал	5,841,400.00	5,109,166.40	732,233.60	87.5%
Ажилгүйдлийн даатгал	1,460,200.00	1,255,020.69	205,179.31	85.9%
Эрүүл мэндийн даатгал	14,229,200.00	12,588,668.57	1,640,531.43	88.5%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	155,074,800.00	198,601,100.00	(43,526,300.00)	128.1%
Гэрэл, цахилгаан	9,675,700.00	12,404,800.00	(2,729,100.00)	128.2%
Түлш халаалт	132,469,200.00	168,956,800.00	(36,487,600.00)	127.5%
Цэвэр, бохир ус	12,929,900.00	17,239,500.00	(4,309,600.00)	133.3%
Норматив зардал	111,742,400.00	95,897,290.00	15,845,110.00	85.8%
Хоол, хүнс	111,742,200.00	95,897,290.00	15,845,110.00	85.8%
Эд хогшил худалдан авах	1,750,000.00	1,750,000.00		100%
Урсгал засвар	1,750,000.00	1,750,000.00		100%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,667,500.00	1,770,900.00	(103,400.00)	106.2%
Мэдээллийн технологийн зардал	1,667,500.00	1,770,900.00	(103,400.00)	106.2%
Бараа үйлчилгээний бусад зардал	24,219,800.00	23,056,700.00	1,163,100.00	95.2%
Бараа үйлчилгээний бусад зардал	19,217,400.00	19,100,800.00	116,600.00	99.4%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,002,400.00	3,955,900.00	1,046,500.00	79.1%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,110,671,000.00	1,148,866,740.00	(38,195,740.00)	103.4
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	953,329,000.00	950,704,500.00	2,645,500.00	99.7%
Тусгай зориулалтын шилжүүлэг санхүүжих	953,329,000.00	950,704,500.00	2,645,500.00	99.7%
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	157,342,000.00	200,351,100.00	(43,009,100.00)	127.3%
Орон нутгийн төсвөөс	157,342,000.00	200,351,100.00	(43,009,100.00)	127.3%

Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		(2,188,860.00)	2,188,860.00	
Урьд оны үлдэгдлээс санхүүжих		(2,188,860.00)	2,188,860.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		9,760,130.67	(9,760,130.67)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		(122,455,817.05)	122,455,817.05	
АЖИЛЛАГСДЫН ТОО	42	42		100%
Удирдах ажилтан	1	1		100%
Гүйцэтгэх ажилтан	24	24		100%
Үйлчлэх ажилтан	17	17		100%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэг нь эрхэм зорилгоо “Хүүхэд бүрийг бие сэтгэлээр эрүүл өсөн бойжиход багш, эцэг эх дэмжигч байж, биеэр үлгэрлэн дагуулж, амьдрах ухаанд чиглүүлэн, өөрийн бүтээлч үйлээр хөгжих боломж олгоно” гэж тодорхойлсон байна. Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь анхан шатны боловсрол олгох гэсэн байна.

Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэг нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 17 зорилт, хэрэгжүүлэх 70 арга хэмжээтэй баталснаас нийт 99.0%-тай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал: Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас хяналт, шалгалтын ажил хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна..

Тус байгууллагын 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/22 тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 95,292.6 мянган төгрөгөөр буюу 12.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,760.1	122,455.8	112,695.7
Бараа материал	105,324.9	113,921.6	8,596.7
Үндсэн хөрөнгө	644,612.4	618,612.6	(25,999.7)
Авлага	1.9	1.9	-
Нийт хөрөнгө	759,699.3	854,991.9	95,292.7
Өглөг	2,194.6	25,473.5	23,278.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	757,504.7	828,961.8	71,457.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	759,699.3	854,991.9	95,292.6

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 122,455.8 мянган төгрөгөөр өссөн нь жилийн эцэст зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 8,596.7 мянган төгрөгөөр өссөн нь эцэг эхчүүдээс хүлээн авсан хүүхдийн ариун цэвэр, бичиг хэргийн материалыг бүртгэж эхэлсэн, мөн 1,937.0 мянган төгрөгийн бараа материалыг Боловсрол, шинжлэх ухааны яамнаас үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд машин тоног төхөөрөмж 12,001.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 7,949.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан хөрөнгө байхгүй. Энэ нь тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 7,147.1 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 5,925.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 2,024.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 4,853.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 734,365.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 172,613.6 мянган төгрөг, нийт 906,978.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэг нь дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 68,174.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийг 1,110,671.0 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 1,110,671.0 мянган төгрөгөөс 2 удаа тодотгол хийж 1,110,671.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,110,671.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, зарцуулсан байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,036,642.2 мянган төгрөг буюу 92.9 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.	71801- Сургуулийн өмнөх боловсрол				
1.1	81605-Эрүүл мэндийг дэмжих	2,501.2	2,501.2	0.00	100%
1.2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	111,742.4	95,897.3	15,845.1	85.5%
1.3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	5,210.8	5,210.8	0	100%
1.4	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	2,501.2	2,384.5	116.7	95.3%
1.5	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	608,625.2	508,410.7	100,214.5	83.4%
1.6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	229,636.8	221,808.6	7,828.2	96.6%
1.7	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	156,824.8	200,351.1	(43,526.3)	127.8%
	Дүн	1,117,042.4	1,036,564.2	80,478.2	92.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн нь Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэг нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 301,928.3 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: Хүүхдийн хоол хүнс 104,907.0 мянган төгрөгөөр нээлттэй тендер шалгаруулахаар, 33,081.4 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардал, бичиг хэрэг, хичээл үйлдвэрлэл, төлбөр хураамжийн зардлуудыг шууд худалдан авалтаар, 73,282.7 мянган төгрөгийн тогтмол зардлыг шууд гэрээ байгуулахаар тус бүр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна. Худалдан авалтын дүн цэцэрлэгийн хүүхдийн тоо багассантай холбоотой 12,509.5 мянган төгрөгийн хоол, хүнсийг зарцуулаагүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав хэрэгжүүлж, дараагийн хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,002,988.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 15,344.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 11,508.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус цэцэрлэг нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан бараа,ажил үйлчилгээний зардлыг 1,163.1 мянган төгрөгөөр хэмнэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 159 төрийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих 159 мэдээллээс, 151 мэдээллийн хугацаандаа, 4 мэдээлэл хугацаа хоцроож, 4 мэдээллийн мэдээлэх хугацаа болоогүй хүлээгдэж байна. Шилэн дансанд байршуулах мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэт, хуулийн хугацаанд багтаан мэдээлсэн байна

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөнийг 87.2% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн 16 тоот албан тоотоор хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	90,856.7	3	79,300.9	87.2%
Нийт дүн	3	90,856.7	3	79,300.9	87.2%

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэгт дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 2,661,388.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдэл 1,097,757.2 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Тайлант жилийн эд хөрөнгийн тооллогын үр дүнг хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулгаж нэгтгээгүй, илтгэх хуудсыг хянаж хүлээн аваагүй 1,563,630.8 мянган төгрөг байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1-д “Үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн тооллогоор бэлэн байгаа үлдэгдэл, нягтлан бодох бүртгэлээр байвал зохих үлдэгдлийн хоорондын зөрүүг дор дурдсан журмаар тохируулан тооцно” гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 35,580.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 26,030.1 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 9,550.5 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

Тайлант онд түлш халаалт, цэвэр бохир усны үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор түлш халаалт, цэвэр бохир ус нийт 25,473.5 мянган төгрөг, бэлтгэн нийлүүлэгч 2 байгууллагын 556.6 мянган төгрөгийн нийт 26,030.1 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүлээ,

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.10-т “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол;" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Жилийн эцсийн санхүүгийн тайлангаарх бусад хангамжийн материалын эцсийн үлдэгдэл тооллогын илтгэх хуудастай тулган шалгахад 1,138.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж хөрөнгийн тооллогыг үр нөлөөтэй хийж хэвших

2. Газрын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Газар эзэмших эрхийн гэрчилгээнд Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор сургуулийн Б байрны 181800591 нэгж талбарын дугаар 1,577,980 м.кв газрыг кадастрын бүртгэлтэй тулган шалгахад 3,623 м.кв-р илүү бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална 5.1.3-т жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4-т үнэн зөв байх" зарчмыг хэрэгжүүлэн ажиллах" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д "Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж газрыг үндсэн хөрөнгийн тайланд бүртгэж тайлагнах

3. Зардлын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цахим төлбөрийн баримтын бүрдэл хангагуй 8,411.7 мянган төгрөгийн зардлын гүйлгээ хийгдсэн байна. Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 4.1.13-д "нэмэгдсэн өртгийн албан татварын падаан" гэж тухайн төлбөр тооцоо хийснийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар, албан татвар суутган төлөгчийн буюу худалдаа эрхлэгч, худалдан авагч албан татвар суутган төлөгчийн нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримт", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох заавар журмын дагуу цахим төлбөрийн баримтын бүрдэл хангасан гүйлгээ хийж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлагналтай холбоотой алдаа	1	1,097,757.2			1	1,097,757.2	1	1,097,757.2				
Хөрөнгийн тооллого	1	1,563,630.8	1	1,563,630.8			1	1,563,630.8				
Дүн	2	2,661,388.0	1	1,563,630.8	1	1,097,757.2	2	2,661,388.0				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өр төлбөр үүсгэсэн.	1	26,030.1			1	26,030.1						
Бараа материалын тооллогын дүн зөрүүтэй.	1	1,138.8					1	1,138.8				
Газар эзэмших эрхийн гэрчилгэн дэх нэгж талбарын м.кв зөрүүтэй.	1	-					1	-				
Анхан шатны баримтын бүрдүүлээгүй	1	8,411.7					1	8,411.7				
Дүн	4	35,580.6			1	26,030.1	3	9,550.5				



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 106-17225502-ТӨА-2024/272/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд түлш халаалт, цэвэр бохир усны үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор түлш халаалт, цэвэр бохир ус нийт 25,473,515.45 төгрөг, бэлтгэн нийлүүлэгч 2 байгууллагын 556,592.00 төгрөг, нийт 26,030,107.45 төгрөгийн өглөг үүсгэж ажилласан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг, Санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өр, төлбөрийг барагдуулан ажиллах, дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Зуунмод сумын Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн эрхлэгч А.Оюунтулга, нягтлан бодогч Б.Эрхэмбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ